



ЗООНОЗЫН ӨВЧИН СУДЛАЛЫН ҮНДЭСНИЙ ТӨВИЙН ЗАХИРЛЫН ТУШААЛ

2025 оны 03 сарын 24 өдөр

Дугаар 416

Улаанбаатар хот

Олон улсын эрдэм шинжилгээний хурал зохион байгуулах тухай

Зоонозын өвчин судлалын үндэсний төвийн дүрмийн 3 дугаар зүйлийн 3.1.5, 3.1.6 дахь заалтууд, төвийн Удирдлагын зөвлөлийн 2025 оны 01 дүгээр сарын 07-ны өдрийн 01 дүгээр хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Зоонозын өвчний тулгамдсан асуудал” олон улсын эрдэм шинжилгээний 26 дугаар хурлыг “Yersinia-15” олон улсын симпозиумтай хамтатган 2025 оны 09 дүгээр сарын 16, 17-ны өдрүүдэд зохион байгуулсугай.

2. Олон улсын эрдэм шинжилгээний хурлыг зохион байгуулах бэлтгэл ажлыг хангах ажлын хэсгийг нэгдүгээр, Судлаачдын ирүүлсэн материалыг хянан тохиолдуулах редакцийн зөвлөлийг хоёрдугаар, Хуралд ирүүлэх материалд тавигдах шаардлагыг гуравдугаар, Шилдэг ханын илтгэл шалгаруулах журмыг дөрөвдүгээр, Зохион байгуулах ажлын төлөвлөгөөг тавдугаар хавсралтаар тус тус баталсугай.

3. Олон улсын эрдэм шинжилгээний хурлыг төлөвлөгөөний дагуу өндөр түвшинд зохион байгуулахыг Ажлын хэсгийн ахлагч (Д.Алтантогтох)-д, ирүүлсэн материалуудыг шаардлагад нийцүүлэн хянан тохиолдуулах, хэлэлцүүлэх, шилдэг ханын илтгэлийг шалгаруулах ажлыг чанартай зохион байгуулж ажиллахыг Редакцийн зөвлөлийн нарийн бичгийн дарга (Д.Цэрэнноров)-д тус тус үүрэг болгосугай.


4. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Захиргааны албаны дарга (У.Нямжаргал)-д даалгасугай.

ЗАХИРЛЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ХАВСРАН ГҮЙЦЭТГЭГЧ



Б.АМГАЛАНБАЯР

Зоонозын өвчин судлалын үндэсний төвийн
Захирлын албан үүргийг хавсран гүйцэтгэгчийн
2025 оны .03 дүгээр сарын 24-ны өдрийн
146 дугаар тушаалын нэгдүгээр хавсралт



ОЛОН УЛСЫН ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ ХУРАЛ
ЗОХИОН БАЙГУУЛАХ АЖЛЫН ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН

- Ажлын хэсгийн ахлагч: Д.Алтантогтох (Эрдэм шинжилгээ, сургалт, мэдээлэл технологийн албаны дарга)
- Нарийн бичгийн дарга: Х.Цэрэнсүрэн (Эрдэм шинжилгээ, сургалт, мэдээлэл технологийн албаны Эрдэм шинжилгээний ажилтан)
- Гишүүд:
- У.Нямжаргал (Захиргааны албаны дарга)
 - Х.Ариунболд (Нийгмийн эрүүл мэнд, тандалт, шуурхай удирдлагын албаны дарга)
 - У.Өнөрсайхан (Лавлагаа лабораторийн албаны дарга)
 - С.Мөнхчимэг (Ерөнхий нягтлан бодогч)
 - Ц.Хишигжаргал (Ариутгал, халдваргүйтгэл биоүйлдвэрлэлийн албаны дарга)
 - Б.Болдбаатар (Санхүү, хангамж, нөөцийн албаны дарга)
 - Б.Уянга (Захиргааны албаны Төсөл хөтөлбөр, гадаад харилцаа хариуцсан мэргэжилтэн)
 - Ц.Баяр (Эрдэм шинжилгээ, сургалт, мэдээлэл технологийн албаны Амьтан судлагч)
 - Б.Лхагвасүрэн (Эрдэм шинжилгээ, сургалт, мэдээлэл технологийн албаны Сүлжээний инженер)

Зоонозын өвчин судлалын үндэсний төвийн
Захирлын албан үүргийг хавсран гүйцэтгэгчийн
2025 оны 03 дүгээр сарын 16-ны өдрийн
416 дугаар тушаалын хоёрдугаар хавсралт

ТТ35150.9092005

РЕДАКЦИЙН ЗӨВЛӨЛИЙН БҮРЭЛДЭХҮҮН

Ерөнхий редактор: Н.Цогбадрах Анагаах ухааны доктор, дэд профессор,
Зоонозын өвчин судлалын үндэсний төвийн Эрдмийн
зөвлөлийн дарга

Нарийн бичгийн дарга: Д.Цэрэнноров Биологийн ухааны доктор, Зоонозын өвчин
судлалын үндэсний төвийн эрдэмтэн нарийн бичгийн дарга

Гишүүд: Б.Ариунсанаа Анагаах ухааны доктор, Зоонозын өвчин
судлалын үндэсний төвийн Эрдмийн зөвлөлийн гишүүн.
АШҮИС-ийн Биоанагаахын сургуулийн профессор.

Б.Болдбаатар Мал эмнэлгийн ухааны доктор, Зоонозын өвчин судлалын үндэсний төвийн Эрдмийн зөвлөлийн гишүүн. ХААИС, Мал эмнэлгийн сургуулийн профессор.

Ж.Мягмар Анагаах ухааны доктор, Зоонозын өвчин судлалын үндэсний төвийн Эрдмийн зөвлөлийн гишүүн.

Ж.Оюунбилэг Биологийн шинжлэх ухааны доктор, Зоонозын өвчин судлалын үндэсний төвийн Эрдмийн зөвлөлийн гишүүн.

Д.Отгонбаатар Анагаах ухааны доктор, Зоонозын өвчин судлалын үндэсний төвийн Эрдмийн зөвлөлийн гишүүн.

Б.Уянга Анагаах ухааны доктор, Зоонозын өвчин судлалын үндэсний төвийн Төсөл хөтөлбөр, гадаад харилцаа хариуцсан мэргэжилтэн.

Х.Цэрэнсүрэн Мал эмнэлгийн ухааны доктор, Зоонозын өвчин судлалын үндэсний төвийн эрдэм шинжилгээний ажилтан.

А.Эрдэнэбат Анагаах ухааны доктор, Зоонозын өвчин судлалын үндэсний төвийн Эрдмийн зөвлөлийн гишүүн.

Д.Алтантогтох Биологийн шинжлэх ухааны магистр, Зоонозын өвчин судлалын үндэсний төвийн Эрдэм шинжилгээ, сургалт, мэдээлэл технологийн албаны дарга.

Зоонозын өвчин судлалын үндэсний төвийн
Захирлын албан үүргийг хавсран гүйцэтгэгчийн
2025 оны 03 дүгээр сарын 24-ны өдрийн
146 дугаар тушаалын гуравдугаар хавсралт

**“ЗООНОЗЫН ХАЛДВАРЫН ТУЛГАМДСАН АСУУДАЛ”
ОЛОН УЛСЫН ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ ХУРАЛД ХЭЛЭЛЦҮҮЛЭХ
МАТЕРИАЛД ТАВИГДАХ ШААРДЛАГА**

“Зоонозын халдварын тулгамдсан асуудал” сэдэвт олон улсын эрдэм шинжилгээний хурал 2025 оны 09 дүгээр сарын 16, 17-ны өдөр Улаанбаатар хотноо зохион байгуулагдана.

Зоонозын гаралтай халдварууд, шинэ болон сэргэж буй халдварт өвчин, хайхрагддаггүй өвчин зэрэг сэдвийн хүрээнд гүйцэтгэсэн судалгааны ажлын үр дүнгээ дотоодын болон олон улсын судлаачдад түгээх, туршлага, мэдлэгээ харилцан солилцох зорилгоор эрдэмтэн, судлаач та бүхэн өөрийн илтгэлийн хураангуйг дараах шаардлагын дагуу бичиж ирүүлнэ үү.

Илтгэлийн хураангуйд тавигдах шаардлага:

1. Хурлын илтгэлийг зөвхөн хураангуй (abstract) хэлбэрээр Монгол, Англи хэлээр товч тодорхой бичнэ.
2. Хураангуйн эхэнд бүтээлийн нэр, зохиогчийн нэр, зохиогчийн харьяалагдах байгууллагын нэр, гол судлаачийн и-мэйл хаягийг бичнэ. Жишээ нь:

БолдГ.¹, Бат Ц.²

¹Шинжлэх ухааны академи

²Зоонозын өвчин судлалын үндэсний төв

И-мэйл: bat@nczd.gov.mn

3. Үсгийн фонт: Arial, үсгийн хэмжээ 12, мөр хоорондын зай 1 (Single)
4. Илтгэлийн хураангуйг удиртгал, материал, арга зүй, үр дүн, хэлцэмж, дүгнэлт гэсэн бүрэлдэхүүн хэсгүүдийг баримтлан боловсруулсан байх ба ном зүйн жагсаалтыг оруулах шаардлагагүй.
5. Монгол, Англи хураангуй нь ижил агуулгатай байх бөгөөд тус бүр 500 хүртэлх үгэнд багтаан бичсэн байна. Түлхүүр үгийг Монгол, Англи хувилбарт адилхан оруулна.
6. Илтгэлийн хураангуйг altantogtokh@nczd.gov.mn болон nczd@nczd.gov.mn цахим хаягаар **2025 оны 06 дугаар сарын 20-ийг** хүртэл хүлээн авна.
7. Хурлын Редакцийн зөвлөл илтгэлийн хураангуйг хянан тохиолдуулж сонгон шалгаруулсны дараа илтгэх цагийг баталгаажуулсан хөтөлбөрийг танд илгээх болно.
8. Тус олон улсын хуралд ирүүлсэн материалуудыг хурлын эмхэтгэлд нийтэлж, олон нийтэд түгээх болно.

Холбоо барих: Зоонозын өвчин судлалын үндэсний төв

Хаяг: Монгол Улс, Улаанбаатар хот, 18131, Сонгинохайрхан дүүрэг 20 дугаар хороо

Утас: +976 70282853, +976 99040664, www.nczd.gov.mn.

Зоонозын өвчин судлалын үндэсний төвийн
Захирлын албан үүргийг хавсран гүйцэтгэгчийн
2025 оны 03 дүгээр сарын 24-ны өдрийн
446 дугаар тушаалын дөрөвдүгээр хавсралт

ТТЗ5150-49092005

ШИЛДЭГ ХАНЫН ИЛТГЭЛ ШАЛГАРУУЛАХ ЖУРАМ

Нэг. Үндэслэл

- 1.1. Зоонозын өвчин судлалын үндэсний төвөөс “Зоонозын халдварын тулгамдсан асуудал” сэдэвт олон улсын эрдэм шинжилгээний хурлыг 2 жил тутамд уламжлал болгон зохион байгуулж байна.
- 1.2. Зоонозын халдварын чиглэлээр онол, практикийн ач холбогдол бүхий судалгаа шинжилгээний шинэ бүтээлийг хөгжүүлэх, дэлгэрүүлэх, эмч, мэргэжилтэн, судлаачдын эрдэм шинжилгээний ажлыг дэмжих, ур чадварыг дээшлүүлэх, эрдэм шинжилгээ, судалгааны ажлын чадавхийг сайжруулах, шинэ санаа, мэдлэгээ харилцан хуваалцах, туршлага солилцох зорилгоор шилдэг илтгэлийг шалгаруулан урамшуулна.

Хоёр. Илтгэлийн шалгаруулалт

- 2.1. Ханын илтгэлийг 2 байр эзлүүлж шалгаруулна. Ханын хэлбэрээр хэлэлцүүлэх илтгэлүүдийг Редакцийн зөвлөлийн гишүүд шалгуур үзүүлэлтийн дагуу үнэлнэ. Редакцийн зөвлөлийн гишүүн бүр хэлэлцүүлж буй илтгэлд шалгуур үзүүлэлтүүдээр 1-5 оноо өгч үнэлэх ба үнэлгээний нийлбэрээр хамгийн өндөр оноо авсан дарааллаар байр эзлүүлнэ. Шалгуур үзүүлэлт: Дараах 6 шалгуур үзүүлэлтээр үнэлнэ.
- 2.2. Судалгааны шинжлэх ухааны үндэслэл
 - 2.2.1. Судалгааны шинэлэг санаа, ач холбогдол;
 - 2.2.2. Судалгааны зорилго, зорилтоо биелүүлсэн байдал;
 - 2.2.3. Судалгааны арга зүй, үр дүнд статистик боловсруулалтын хийсэн байдал;
 - 2.2.4. Асуудлыг шинжлэх ухааны үндэслэлтэй дүгнэсэн байдал;
 - 2.2.5. Илтгэлийн бүтэц, хэл найруулга;

Гурав. Шагнал

- 3.1. Шилдэг ханын илтгэл
 - I байр: 1 илтгэл – Өргөмжлөл, мөнгөн шагнал, дурсгалын зүйл;
 - II байр: 1 илтгэл – Өргөмжлөл, мөнгөн шагнал, дурсгалын зүйл;